




БАТЛАВ

САЛБАРЫН УЛСЫН
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

/Албан тушаал/



Д.РЕНЧИНДОРЖ

/Гарын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УДИРДАМЖ

2024 оны 03 дугаар сарын 13

Дугаар 05-00-00-001/03

Улаанбаатар хот

Урьдчилан сэргийлэх хяналт
шалгалт хийх тухай

Нэг.Шалгалтын зорилго, үндэслэл

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”, 2023 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 420 дугаар тогтоол, Соёлын сайдын 2023 оны “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/317 дугаар тушаалын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын үйл ажиллагаанд Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Музейн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, дүгнэлт гаргах, холбогдох газруудад шалгалтын дүнг танилцуулан шийдвэр гаргуулахад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын зорилго оршино.

Хоёр.Шалгалтад хамрагдах асуудал, хүн, хуулийн этгээд, объектын нэр

2.1.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогын үйл ажиллагаанд тавих урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад Соёлын сайдын 2023 оны “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/317 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж байгаа соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэлтэй төрийн болон орон нутгийн өмчийн музей, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургууль, холбогдох байгууллага, танхим, шашны байгууллагад хийх тооллогын ажил, салбар комиссын үйл ажиллагаа, тайлан, холбогдох байгууллагыг хамруулна.

2.2.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг салбарын төлөвлөгөөт шалгалт хийхээр зарласан байгууллага, объектод хийх хяналт шалгалттай уялдуулан гүйцэтгэх бөгөөд салбар

комиссын тайланд гаргасан дүгнэлт, танилцуулгын хамт аймаг, нийслэлийн хэмжээнд нэгтгэн ирүүлнэ.

2.3.Хяналт шалгалтаар Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын дагуу тооллоготой холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Соёлын сайдын 2023 оны “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/317 дугаар тушаалын хэрэгжилтэд хяналт тавина.

2.4.Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэд, зөрүүгүй байх шаардлагыг нягтлан, тулган шалгаж зөрчлийг арилгуулна.

2.5.Тооллогод хамрагдсан дурсгалаас сонгон, тооллогын дэвтэрт бичигдсэн дурсгалт зүйлийн хувийн дугаар, нэр, тодорхойлолт, тоо ширхэг, материал, хэмжээ, жин, хадгалалтын байдлыг илэрхийлсэн бичвэртэй тулган шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллана.

2.6.Салбар комиссын тайланд хийх соёлын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэд тооллогын ажил холбогдох хууль, журмын дагуу явагдсан эсэх, тооллогод хамрагдсан дурсгалт зүйлийн тоо болон дутсан, солигдсон, хулгайд алдагдсан (2018-2019 оны улсын тооллогоос хойш), мэдээллийг засварласан, дурсгалт зүйлийн талаарх мэдээлэл болон хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тодорхой тусгана.

2.7. Салбар комисс, шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомж, шаардлагад нийцсэн мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

2.8.Хяналт шалгалт хийх явцад хүн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл ирүүлсэн тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж шийдвэрлэнэ.

2.9.Тооллогын ажлын үеэр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулна.

2.10.Хяналт шалгалтын явцад Зөрчлийн хуульд заасан зөрчил илэрсэн тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дагуу зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж хянан шийдвэрлэнэ.

Гурав.Шалгалтын төрөл

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт

Дөрөв.Шалгалтын арга

4.1.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

4.2. Улсын (ахлах) байцаагч нь салбар комиссын тайлан, мэдээ, хуулийн этгээдийн холбогдох баримт бичгийг судалж танилцах, хянаж үзэх, тайлбар авах, баримт бичгийг хуулбарлан баталгаажуулах, холбогдох төрийн захиргааны байгууллагуудад хадгалагдаж байгаа баримт бичгүүдийг гаргуулж авах, тулгаж үзэх, үзлэг хийх, хувилж авах, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг баримтжуулан хуулбарлаж авах, фото зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг хууль тогтоомжид заасан бусад аргуудаар хийж гүйцэтгэнэ.

4.3. Шалгалт хийхдээ шаардлагатай баримт бичиг, бусад холбогдох судалгаа, мэдээллийг шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хүлээн авч, шалгалт дууссаны дараа хүлээлгэж өгөх ба шаардлагатай тохиолдолд нотлох баримт болгохоор хувилж авна.

Тав.Шалгалт хийх бүрэлдэхүүн

5.1. Хяналт шалгалтыг нийслэлд Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар, нийслэлийн Соёл, урлагийн газрын соёлын хяналтын улсын /ахлах/ байцаагч хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд орон нутагт ажиллана.

5.2. Орон нутагт хяналт шалгалтыг соёлын хяналтын улсын /ахлах/ байцаагчид хийж гүйцэтгэнэ.

5.3. Хяналт шалгалтын явцад мэргэжлийн байгууллага, тусгай мэдлэг бүхий хүн, шинжилгээ хийх эрх авсан шинжээчийг татан оролцуулж, хамтран хийж гүйцэтгэж болно.

Зургаа.Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэрэгжүүлнэ.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

7.1. Хяналт шалгалтын танилцуулгыг аймаг, нийслэлээр нэгтгэж, хяналт шалгалтын танилцуулга, улсын байцаагчийн үйлдсэн баримт бичгийн хамт 11 дүгээр сарын 01-ний дотор Соёлын яамны Салбарын хяналтын газарт бичгээр болон цахимаар ирүүлнэ.

7.2.Төлөвлөгөөт шалгалтын дүнг Салбарын хяналтын газар нэгтгэж, танилцуулгыг 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох албан тушаалтанд танилцуулна.

--- оОо ---